

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2023. 12. 27

Байгууллагын нэр:

Цагдаагийн ерөнхий газар

Нэгжийн нэр:

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн
байгууллага

Албан тушаалтны нэр:

Эргүүлийн офицер

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТТ-8

Ажлын цаг:

8 цаг

Ажлын байрны албан ёсны нэршил:

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн
байгууллагын байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Байгалийн гамшиг, гол түймэр, хүн, малын
гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн болон
бусад аюул тохиолдсон, нийтийн эмх
замбараагүй байдал үүссэн, террорист
халдлага, онц болон дайны байдал
зарласан, онц ноцтой гэмт хэрэг үйлдэгдсэн
зэрэг зайлшгүй тохиолдолд өндөржүүлсэн
бэлэн байдалд ажиллах.

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ.

Албан тушаалын зорилго:

Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг
үүргийг хэрэгжүүлэх, нийтээр дагаж мөрдөх хууль тогтоомжийг сахиулах чиглэлээр эргүүл хийх,
хуулиар харьяалуулсан зөрчлийг шалгаж шийдвэрлэх, удирдлагаас өгсөн үүрэг, ажлын чиглэл,
зөвлөмжийг биелүүлэх.

Албан тушаалын зорилт:

1. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг
үүргийг хэрэгжүүлэх, нийтээр дагаж мөрдөх хууль тогтоомжийг сахиулах чиглэлээр эргүүл хийх,
хуулиар харьяалуулсан зөрчлийг шалгаж шийдвэрлэх;
2. Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн ажлын байрны зорилгод нийцсэн бусад чиг
үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т, Хариуцан Гүйцэтгэх-Г, Хянах-Х, Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1.1.Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хэрэгжилтийг хангах, үр дүнг тайлагнах;</p> <p>1.2.Хууль тогтоомж, дээд шатны байгууллага, албан тушаалтан удирдлагаас гаргасан шийдвэр, үүрэг, ажлын чиглэл, албан даалгавар, заавар, зөвлөмж, хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх;</p> <p>1.3.Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд эргүүл харуулын дүрмийг хэрэгжүүлэх, /явган, морь, нохой, мото, авто, завыт, нохойт/ бусад эргүүлд ажиллах, тээврийн хэрэгсэлд үзлэг шалгалт хийх;</p> <p>1.4.Нийтийн хэв журам хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, зөрчлийг шалгаж шийдвэрлэх, эцэг, эх, асан хамгаалагч, харгалзан дэмжигчийн хараа хяналтгүй болсон хүүхэд, гээгдэл эд хөрөнгө, алдуул малыг бүртгэх түүнтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх, эрх бүхий байгууллага, албан тушаалтны даалгасан сураггүй алга болсон хүнийг эрэн сурвалжлах, дээрх чиглэлээр гарсан хууль, дүрмийн хэрэгжилтийг хангаж ажиллах;</p> <p>1.5.Гэмт хэрэг, захирагааны зөрчлийн талаар гомдол, мэдээлэл хүлээн авах, гэмт хэрэг, зөрчлийн газрыг хамгаалах, хойшилуулшгүй ажиллагаа явуулах, хуулиар харьяалуулсан зөрчлийг шалгаж, шийдвэрлэх, холбогдох албан тушаалтанд шилжүүлэх;</p> <p>1.6.Хорио цээр, хязгаарлалтын дэглэм сахиулах, нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага гарсан, онц болон дайны байдал зарласан үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах, жагсаал, цуглааныг албадан тараах ажиллагаа, нийтийг хамарсан арга хэмжээний үеийн хамгаалалтад ажиллах, удирдлагыг мэдээ, мэдээллээр хангах, өгсөн үүргийг хэрэгжүүлэх, үр дүнг танилцуулах;</p>	Хуульд заасан чиг үүргийн хэрэгжилт хангагдаж, ажлын үр дүн бодитой үнэлэгдэж, үйл ажиллагаа сайжирна.	Г Г Г Г Г Г Г Г
2 дугаар зорилтын хүрээнд	<p>2.1.Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль, Төрийн тусгай хамгаалалтын газартай хамтран ажиллах журамд заасны дагуу төр засгийн тэргүүн, гадаадын өндөр хэмжээний зочин, төлөөлөгчийн айлчлалын үед хамгаалалт, зохицуулалтыг зохион байгуулах ажилд удирдлагын шийдвэрээр оролцох;</p> <p>2.2.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу гэрч, хохирогчийг</p>	Хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилт хангагдана	Г Г

	<p>хамгаалах ажилд удирдлагын шийдвэрээр биечлэн оролцох;</p> <p>2.3. Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын үр дүн, тайлан, дүн мэдээг сар, улирал, хагас бүтэн жилээр удирдлагад танилцуулах, тайлгнах;</p> <p>2.4.“Цагдаагийн байгууллагын туслах тоо бүртгэлийн заавар”-ын хэрэгжилтийг хангах, бүртгэл, тэмдэглэлийг хөтлөх;</p> <p>2.5.Байгууллагын дотоод журмыг мөрдөх, хариуцуулсан эд хөрөнгө, автомашин, техник, тусгай хэрэгслийг зориулалтын дагуу ашиглах, хадгалах.</p>		Г
	<p>Ажлын байрны зорилгын хүрээнд явуулах бусад үйл ажиллагаа:</p> <p>1.Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн ажлын байрны зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.</p> <p>2.Шууд удирдах албан тушаалтнаас өгсөн хууль ёсны үүрэг даалгаврын биелэлтийг хангах</p> <p>3. Албан хэрэг хөтлөлт, архивын журмыг өдөр тутмын үйл ажиллагаандaa мөрдөж ажиллах</p> <p>4.Төрийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж, байгууллагын ажилтнууд болон харилцагч, үйлчлүүлэгчид иргэдтэй зөв боловсон харьцах ёс зүйн зөрчил дутагдал гаргахгүй байх</p> <p>Шударга ёсны шалгуурыг хангах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар:</p> <p>1.Авлига, хүнд суртлаас ангид байж хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, шударга ёсыг эрхэмлэн “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг чанд сахих;</p> <p>2.Явцуу эрх ашиг сонирхлоос татгалзаж, цагдаагийн байгууллага, албаны нийтлэг эрх ашиг сонирхлыг эрхэмлэн ажиллах.</p>	<p>Ажлын байрны зорилго, зорилт хангагдаж, цагдаагийн алба хаагчийн хуулиар хүлээлгэсэн нийтлэг чиг үүргийн биелэлт хангадана.</p>	Г Г Г Г Г Г Г Г
2 дугаар зорилтын хүрээнд			

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	-Дээд боловсролтой, бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй		
Мэргэжил	-Эрх зүй /0421/, Аюулгүй байдал судлал /103901/, Иргэн, өмч хөрөнгө хамгаалал /1032/;		
Мэргэшил	-Албан тушаалын мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх.		
Туршлага	Цагдаагийн байгууллагад 3-аас доошгүй жил үр бутээлтэй ажилласан байх.		
Үр чадвар	Дүн шинжилгээ хийх	-Мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх -Гүйцэтгэж буй ажлын явц, үр дунг тайлгнах -Судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй	
	Асуудал шийдвэрлэх	-Өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах -Шаардлагатай асуудлаар судалгаа хийж, дунг хариуцах	

	Багаар Ажиллах	- Өөрийн мэдлэг ур чадвар, өөрт байгаа мэдлэгийг баг хамт олонгойгоо хуваалцаж хамтран ажиллах. - Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох.
	Бусад	

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр: Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах тасгийн дарга	Бусад харилцах субъект:
Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр, тоо:	Шууд харилцах: Хариуцсан асуудлаар бусад яам, агентлагийн албан тушаалын адил болон түүнээс доош зэрэглэлтэй албан тушаалтан.
Батлагдсан орон тоо	Шууд бус харилцах: Төрийн бус байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, олон улсын байгууллага /Эдгээртэй харилцахдаа Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж, үйл ажиллагааны журмын холбогдох заалтыг баримтална/.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА  T.ГАНЗОРИГ	Байгууллагын нэр:..... Шийдвэрийн огноо:..... Дугаар:.....
2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр	
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:	
<u>Байгууллагын нэр: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР</u>	
Шийдвэрийн огноо: 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр. Дугаар: 1/101	
ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА	
 T.СУХБОЛД 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр	

Танилцсан:

Албан тушаалтан:

20... оны дугаар сарын-ны өдөр